

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225-р тогтоолоор шинэчлэн баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4-р хавсралт



**ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /Маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

| | |
|--|--|
| Тайлагнах хугацаа: | 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | "Гермес Центр" ХК УБГД: 9010001069 Үнэт цаасны код: MN00HRM05287 Утасны дугаар: (+976) 11 301 577 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр: | Монголын хөрөнгийн бирж |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар : | Түрээс |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан компанийн нэр: "Си Эс Ай Аудит" ХХК, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн огноо: 2015 он |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: | 78 543 001 |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Жилийн тайланг бэлтгэсэн: Нягтлан бодогч О.Энхтуяа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэн Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг |

| | | | | |
|---|--|---------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | Тайлант жилийн санхүүгийн тайлан (хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайлант хавсаргана.) | | | |
| | | Огноо | 2023.01.01 | |
| | | | 2023.12.31 | |
| | | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | |
| | | | Эцсийн үлдэгдэл | |
| | Санхүү байдлын үзүүлэлт | Хөрөнгө | | |
| | | Эргэлтийн хөрөнгө | 2,683,718,091.98 | 3,059,554,027.57 |
| | | Эргэлтийн бус хөрөнгө | 6,059,057,008.83 | 5,895,810,984.26 |
| | | Нийт хөрөнгө | 8,742,775,100.81 | 8,955,365,011.83 |
| | | Өр төлбөр ба эздийн өмч | | |
| | | Богино хугацаат өр төлбөр | 285,321,309.41 | 360,652,243.85 |
| | | Урт хугацаат өр төлбөр | - | - |
| | | Эздийн өмч | 8,457,453,791.39 | 8,594,712,767.98 |
| | Нийт өр төлбөр ба эздийн өмч | 8,742,775,100.80 | 8,955,365,011.83 | |
| | | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | |
| | | | Эцсийн үлдэгдэл | |
| | | Борлуулалтын орлого | 2,059,006,005.73 | 2,556,454,374.24 |
| | | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| | | Нийт ашиг | 2,059,006,005.73 | 2,556,454,374.14 |

| | | | | |
|-----|--|---|--------------------|--------------------|
| | <i>Орлогын тайлан</i> | Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал | 1,383,407,936.98 | 1,887,022,350.98 |
| | | Орлогын татварын зардал | 138,339,377.57 | 188,702,315.77 |
| | | Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | 1,245,068,559.41 | 1,698,320,035.21 |
| | | Нийт орлогын дүн | 1,245,068,559.41 | 1,698,320,035.21 |
| | <i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i> | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| | | Өмч | 7,854,300,100.00 | 7,854,300,100.00 |
| | | Хуримтлагдсан ашиг | 603,153,691.39 | 740,412,667.98 |
| | | Нийт эздийн өмчийн дүн | 8,457,453,791.39 | 8,594,712,767.98 |
| | <i>Мөнгөн гүйлгээний тайлан</i> | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| | | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 1,120,787,530.70 | 1,520,038,709.38 |
| | | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 236,452,787.71 | 296,004,840.53 |
| | | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (1,062,822,883.44) | (1,441,464,920.67) |
| | | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 294,417,434.97 | 374,578,629.24 |
| | | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,310,006,135.77 | 2,604,423,570.74 |
| | | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,604,423,570.74 | 2,979,002,199.98 |
| 1.1 | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | | | |
| | <i>Си Эс Ай аудит" ХХК нь "Термес Центр"ХК-ийн 2023 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулга нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлт гаргасан</i> | | | |
| 1.2 | Аудитын тодорхойлох захидал (тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурьдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх) | | | |
| | <i>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</i> | | | |
| 2 | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл | | | |
| 2.1 | Үйл ажиллагааны үр /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд | $ROA=0.1896$ $ROE=0.1976$ $EPS=21.62$ | | |
| 2.2 | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | $ROTA=0.21$ | | |
| 2.3 | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл | <i>Манай компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна</i> | | |
| 2.4 | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого (off balance) | <i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</i> | | |

| | | |
|---|--|--|
| 2.5 | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл: | Тайлант хугацаанд авсан зээл болон зээлийн баталгаа байхгүй. |
| 3 | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана./ | |
| <i>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</i> | | |
| 4 | Цалин урамшууллын мэдээлэл: | |
| Тус компани нь 2023 онд ТУЗ-ийн дарга, гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад дараах цалин хөлс, урамшууллыг олгосон болно. Үүнд: | | |
| 1 | ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалинд 21.1 сая төгрөг олгосон. | |
| 2 | Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулалд 99.2 сая төгрөг олгосон. | |
| 5 | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл: | |
| “Гермес Центр” ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус баталсан дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. | | |
| Хувьцаа эзэмшигчдийн хурал | | |
| Манай компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа "Компанийн тухай хууль"-ийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр тогтоосон асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг. | | |
| Компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурал | | |
| Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 7-ны өдөр "Гермес Центр" ХК-ийн оффисын 3-р давхрын хурлын танхимд хуралдав. Хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,801,120 (55.77%) саналын эрхтэй 5 хувьцаа эзэмшигч, хуралд биечлэн оролцож саналаа өгсөн 24,221,646 (30.8%) саналын эрхтэй 15 хувьцаа эзэмшигчид буюу нийт 68,022,766 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцсоноор хурлын ирц 86.61%-тай байлаа. | | |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр | | |
| 1 | Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Гермес Центр” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь 2022 оны батлагдсан төсөв төлөвлөгөөг биелүүлэн хангалттай сайн ажилласан гэсэн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан. | |
| 2 | Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийг хэлэлцэж, улмаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан. | |
| Төлөөлөн Удирдах зөвлөл | | |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байдаг. Компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүнийг 5 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сонгосон. Одоогоор манай компанийн Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй. Компанийн ТУЗ-ийн дэргэд Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороод ажилладаг бөгөөд дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. | | |

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, хурлын ирц болон тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх танилцуулга



**ДУГАРЖАВЫН
ОЮУНСҮРЭН**

ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга

Инженер эдийн засагч
мэргэжилтэй

"Улаанбаатар дахь Америк
ерөнхий боловсролын сургууль"
ХХК-ны гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 29.87%



**НАМСРАЙН
МӨНХЗҮЛ**

ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин
урамшууллын хорооны гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0%



**ДҮВЧИНДОРЖИЙН
АЛТАНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин
урамшууллын хорооны гишүүн

Нягтлан бодогч мэргэжилтэй

"Одод" ХХК-ийн нягтлан бодогч

ТУЗ-ийн хурлын ирц - 75%
Хувьцааны эзэмшил 1.5%



**ДАШЦЭРЭНГИЙН
ТУЯА**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны дарга

Эдийн засагч мэргэжилтэй

"Төрийн банк" ХК-ийн хэлстийн
захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0%



**НЯМЖАВЫН
БАТСАЙХАН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй

"Монгол даатгал" ХХК-ийн
Чингэлтэй салбарын захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 75%
Хувьцааны эзэмшил 0%



**БАЛЖИННЯМЫН
АЛТАНГЭРЭЛ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны гишүүн

Банкны эдийн засагч
мэргэжилтэй

"Ар гурван хэц" ХХК-ийн
гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0%



**БАТСҮХИЙН
ОЮУНЦЭЦЭГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны дарга

Инженер эдийн засагч
мэргэжилтэй

"Гермес Центр" ХК-ийн
гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0.1%



**БУЯНЦОГИЙН
АМАРСАНАА**

ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны гишүүн

Эрх зүйч мэргэжилтэй

"Төрийн банк" ХК-ийн хэлстийн
захирал

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0%



**ЦЭНСҮРЭНГИЙН
ТҮВШИНЖАРГАЛ**

ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны гишүүн

Зураач мэргэжилтэй

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

ТУЗ-ийн хурлын ирц - 100%
Хувьцааны эзэмшил 0.06%

ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, компанийн үйл ажиллагааг зөв зохистой төвшинд хүргэх, зорилго, зорилтоо биелүүлэхэд Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг. Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа танхимаар 4 удаа хуралдаж, нийт 26 асуудлыг хэлэлцэн 11 тогтоол шийдвэрийг гаргасан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын 2023 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд 3 удаа танхимаар хуралдаж, 3 тогтоол, Цалин урамшууллын хороо 2 удаа хуралдаж 1 тогтоол, 1 саналыг тус тус гаргаж ажилласан бөгөөд тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд зэрэг хүний нөөцийн үйл ажиллагаа тогтвортой байгаа учир Нэр дэвшүүлэх хороо хуралдаагүй болно.

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2023 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь өөрийн чиг үүргийн хүрээнд ТУЗ (4), ХЭХ (1), ТУЗ-ийн дэргэдэх хороодын (5) хурлуудыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хууль журамд заасан асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллалаа. Хурлаас гаргасан тогтоол шийдвэр, хурлын тэмдэглэл зэргийг албажуулан баталгаажуулж СЗХ болон МХБиржид хуулинд заасан хугацаанд хүргүүлсэн. Мөн зохицуулагч байгууллагуудад хүргүүлэх хугацаат тайлангуудыг холбогдох маягтын дагуу бэлтгэн, цаг хугацаанд нь хүргүүлж, улмаар МХБиржийн сайт болон өөрийн цахим хуудсанд нийтэлж хувьцаа эзэмшигчдэд компанийн тухай мэдээ мэдээллийг үнэн бодитоор авах боломжийг бүрдүүлж байна. Түүнчлэн ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулж, компанийн үйл ажиллагааны тухай мэдээллийг гишүүдэд дамжуулж, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

Компанийн засаглалын кодекс

Манай компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн дагуу өөрийн компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталж, улмаар холбогдох бодлогын баримт бичиг, заавар журмуудыг шинээр болон шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

"Монголын Хөрөнгийн бирж"-ээс 2022 онд шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодексийг үнэлэх үнэлгээ"-ний аргачлалын дагуу 2023 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаарх "Гермес Центр" ХК-ийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн талаарх мэдээлэл.

| № | Гарчиг | Авбал зохих нийт оноо | 2023 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар | | 2023 оны 11-р сарын 15-ны өдрийн СЗХорооны | |
|--------------------|---|-----------------------|---|-----------------|--|-----------------|
| | | | Үнэлсэн | Үнэлгээний хувь | Хяналтын оноо | Үнэлгээний хувь |
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт | 12 | 12 | 100% | 7 | 58.3% |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 9 | 90% | 7 | 70% |
| 3 | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 4 | Аудит, хяналтын тогтолцоо | 6 | 4 | 66.7% | 4 | 66.7% |
| 5 | Эрсдэлийн удирдлага | 8 | 8 | 100% | 5 | 63% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал | 6 | 6 | 100% | 5 | 83.3% |
| 7 | Оролцогч талуудын эрх ашиг | 8 | 8 | 100% | 6 | 75% |
| 8 | Компанийн соёл | 6 | 6 | 100% | 6 | 100% |
| 9 | Хувьцаа эзэмшигчдийн эрх | 10 | 9 | 90% | 8 | 80% |
| Нэгдсэн дүн | | 72 | 68 | 94.1% | 54 | 75% |

Тус компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг Санхүүгийн Зохицуулах Хорооноос хянан баталгаажуулсан бөгөөд уг үнэлгээгээр үнэлэхэд манай компани 75 хувьтай буюу дунд засаглалтай гэж үнэлэгдсэн болно. Компанийн ТУЗ-өөс 2023 оны засаглалын кодексийн нэгдсэн үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид тус зарчимд нийцүүлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, улмаар үе шаттайгаар сайжруулахаар төлөвлөдөг байна.

Мэдээллийн ил тод байдал, тайлагнал

| | |
|---|--|
| 1 | Компанийн ХЭХ болон ТУЗ-ийн ээлжит хурлуудыг (2023.02.15, 2023.05.26, 2023.08.23, 2023.12.06) холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг СЗХ болон МХБиржид хүргүүлсэн. |
| 2 | Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлуудыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан санал, зөвлөмжийг ТУЗ-ийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд оруулж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан. |
| 3 | Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2022 оны сүүлийн хагас жил, 2023 оны эхний хагас жилийн ногдол ашгийн мөнгийг компанийн төв байр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд бүрэн байршуулан тараасан бөгөөд ногдол ашгийн тайлан мэдээллийг холбогдох журмын дагуу СЗХ болон МХБиржид тус тус хүргүүлэн ажилласан. |
| 4 | СЗХорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу компанийн 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг холбогдох маягтын дагуу бэлтгэж, СЗХ болох МХБ-д тус тус хүргүүлэн ажиллалаа. Мөн МХБ-ийн www.mse.mn цахим хуудас, өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсанд тус тус нийтэлж олон нийтэд мэдээллээ. |
| 5 | Бүртгэлтэй брокер дилерийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн гадаад дотоодын хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг өгч ажиллав. |
| 6 | Компанийн вэб сайт, мэдээллийн самбарны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж ирлээ. |
| 7 | Компанийн ТУЗ-ийн хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс СЗХ болон МХБиржид хэвлэмэл байдлаар тогтмол хүргүүлж, мөн www.mse.mn , www.hermescenter.mn сайтуудад байршуулан олон нийтэд нээлттэй ил тодоор тайлагнан ажиллаж байна. |

6 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Манай компани нь барилгын материалын бизнес эрхлэгчдэд худалдааны талбайн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бидний үйл ажиллагаанд валютын хани болон бараа материалын үнийн өсөлт, улс хоорондын тээвэр ложистикийн асуудлууд голлох эрсдлүүдийг бий болгодог.

7 Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл (5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо)



* Манай "Гермес Центр" ХК нь нийт 78,543,001 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн зах зээлд гаргасан бөгөөд 2024 оны 03-р сарын 07-ны бүртгэлийн өдрөөр 1065 хувьцаа эзэмшигчидтэй болсон байв.

8 Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл:

Олон нийтэд шинээр санал болгон хувьцаа гаргаагүй болно.

9 Ногдол ашгийн мэдээлэл :

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд 2014 оноос эхлэн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашигт нийцүүлэн жилд 2 удаа ногдол ашиг хуваарилж байна. Ногдол ашиг тараалтын тайланг холбогдох журмын дагуу СЗХ, МХБирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол тайлагнаж хэвшсэн.

| Ногдол ашиг хуваарилсан огноо | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг) | Нийт зарласан ногдол ашгийн дүн (сая төг) | Хувьцаа эзэмшигчдийн тоо | Ногдол ашиг олгосон хэлбэр | | Ногдол ашиг тараалтын хувь | |
|-------------------------------|---|---|--------------------------|------------------------------------|-----------------|----------------------------|------|
| | | | | ҮЦТХТөвөөр зуучлуулан бэлэн бусаар | Компани дээрээс | | |
| 2022 | Эхний хагас жил | 8.02 | 629.9 | 1024 | 90.2 | 539.7 | 100% |
| | Сүүлийн хагас жил | 7.50 | 589.1 | 1051 | 84.4 | 504.7 | 100% |
| Нийт | | 15.52 | 1219 | | | | |
| 2023 | Эхний хагас жил | 12.00 | 942.5 | 1056 | 135.0 | 807.5 | 100% |
| | Сүүлийн хагас жил | 9.20 | 722.6 | 1065 | 103.5 | 619.1 | 100% |
| Нийт | | 21.20 | 1665.1 | | | | |

10 Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл :

Манай компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1 *Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсадаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх нийтийн эдэлбэр газрыг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна*

2 *"Непко кидс" ХХК-тай хамтран дэлхийн номын өдөрлөгийг хамтран зохион байгуулж ажиллалаа.*

3 *"Монос" групп-тэй хамтран "Дархлаа дэмжье" аяныг иргэдийнхээ дунд зохион байгууллаа. Аяны хүрээнд ясны сийрэгжилт, цусны даралт, хүчилтөрөгчийн дутагдал, арьсны оношилгоо хийх зэргээр эмнэлэг, гоо сайхны анхан шатны үзлэг оношилгоог хийж, улмаар түрээслэгч иргэдэд мэргэжлийн эмч зөвлөгөөг өгч ажиллав.*


4 *"Худалдаа хөгжлийн банк"-тай хамтран Бритто карт, Хуримтлалтай Монгол хадгаламжийн тухай өдөрлөгийг түрээслэгчдийн дунд зохион байгууллаа. Мөн "Капитрон банк"-тай хамтран гадаад гуйвуулгын картыг хэрхэн ашиглах талаарх мэдээ мэдээллийг өглөө.*

5 *"Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсрол төв"-тэй хамтран Иргэн бүрт эрүүл мэнд сургалтыг түрээслэгчдийн дунд зохион байгууллаа. Энэхүү сургалтын зорилго нь иргэдийн дундаж наслалтыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд сургалтаар хоол зүй, сэтгэл зүй, нойр, дасгал хөдөлгөөн биеийн дархлаа, эрдэс бодисын зөв зохистой хэрэглээний талаарх мэдээллийг түрээслэгч, худалдагч, туслах ажилтнуудад өглөө.*

6 *"Монгол даатгал" ХХК-тай хамтран даатгал гэж юу болох, даатгалын ач холбогдол, даатгалын төрөл зүйл, даатгалын хамрах хүрээ болон даатгуулагчид учирсан аливаа хохирлыг хэрхэн барагдуулах талаарх мэдээ мэдээллийг танилцууллаа.*

7 *Худалдааны төвийн түрээслэгчид, тэдгээрийн худалдагч ажилтнуудад болон иргэдэд зориулан хэрэглээний усны зөв зохистой ашиглалтын талаарх таниулга сурталчилгааг тогтмол хийж ирлээ.*

8 *Баянгол дүүргийн Цахилгаан түгээх сүлжээ төвтэй хамтран "Тогоо тохируулья" нийгмийн нөлөөллийн аянд нэгдэж, улмаар худалдааны төвийн түрээслэгчдэд цахилгаан эрчим хүчний оргил ачааллын үе болох 17:00 – 22:00 цагийн хооронд эрчим хүчний хэрэглээгээ боломжит хэмжээгээр хэмнэж, зөв зохистой хэрэглэх талаарх таниулан сурталчлах ажлыг тогтмол хийж байна. Үүний үр дүнд эрчим хүчийг тодорхой хэмжээнд хэмнэж, Улаанбаатар хотынхоо эрчим хүчний системд дэмжлэг үзүүлэн, улс орныхоо өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллалаа.*

| | |
|---|--|
| 9 | Худалдааны төвийн эргэн тойрон дахь ногоон байгууламжийг байнга тордож, иргэдээ эрүүл ая тухтай, цэвэр цэмцгэр орчинд таатай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна. |
| 10 | Манай худалдааны төвийн захиргаа нь хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх ажлыг цогцоор нь шийдвэрлэн ажиллаж ирсэн бөгөөд энэхүү ажлын хүрээнд түрээслэгчдийн бараа материалын сав баглаа боодол, ус ундааны хуванцар сав зэргийг ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэнд оруулж байна. Үүний үр дүнд 2023 онд 10 гаруй тонн цаасан хог хаягдал болон ус ундааны хуванцар сав, шил зэргийг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт тушаалаа. |
| | Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2024 оны <u>3</u> сарын <u>22</u> ны өдөр |
| Овог, нэр: Батсүх Оюунцэцэг | |
| Албан тушаал: "Гермес Центр" ХК-ийн Гүйцэтгэх захирал | |
| Гарын үсэг: <u>Б. Оюунцэцэг</u> | |
| (Тамга /тэмдэг) | |
|  | |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2024 оны <u>3</u> сарын <u>22</u> ны өдөр | |
| Овог, нэр: Дамдинсүрэн Эрдэнэсүрэн | |
| Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: | |
| Гарын үсэг: <u>Д. Эрдэнэсүрэн</u> | |